



History of the XX Century Mongolia

**1990 REVOLUTION: 2. COLLAPSE OF COMMUNIST REGIME IN
MONGOLIA**

LECTURE 12

LECTURER: PROF. OTGONJARGAL SODNOMDARJAA

NATIONAL UNIVERSITY OF MONGOLIA

XX зууны Монголын Түүх

1990 ОНЫ ХУВЬСГАЛ: 2. МОНГОЛ ДАХЬ “КОММУНИЗМЫН”
МӨХӨЛ


ЛЕКЦ 12

ПРОФ.ОТГОНЖАРГАЛ СОДНОМДАРЖАА

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

Лекцийн агуулга

- Энэ лекцээр Марксист онолын мөн чанарыг ойлгохын дээр аливаа онол мета чанарыг агуулж байдгийг мэдэх болно.
- Монгол төрийн бодлогын залгамж чанар диалектик хөгжлийн ач холбогдлыг ойлгох болно



1911 оны хувьсгалын дараа монгол төрөөс баримталж байсан бодлого 1921 онд үргэлжлэн хэрэгжиж байв.

Гэвч Их гүрний хүчирхийлэлийн улмаас монгол төрийн залгамж чанар алдагдаж зах зээлийн замаас өмчгүй нийгэм рүү шилжсэн юм

1990 оны Монгол дахь хувьсгал, 1911,1921 оны хувьсгалын нэгэн адил Их Гүрний эрхшээлт замаас гарах, тулган хүлээлгэсэн нийгмийн зохиомол харилцаанаас салах, бие даан эрх тэгш хөгжих, чөлөөт зах зээлийн замыг баримжаалах үндсэн зорилтыг өөртөө агуулж байснаараа дээрхи хоёр хувьсгалын зорилтыг гүйцэлдүүлж өгсөн түүхэн ач холбогдол бүхий хувьсгал байв.



<http://archive.olloo.mn>

ЗХУ болон социалист орнуудад дээд мэргэжил
эзэмшсэн, марксист ленинист үзэл суртлаар
хүмүүжсэн залуучууд МУИС-ийн хичээлийн
байруудын хаалган дээр


“Монгол ах дүү нараа, Мориндоо!” “Өнөөдөр
хийвэл маргааш хожно!” “Айвал бүү хий, хийвэл
бүү ай!” “Сайн үйлс дэлгэрэх болтугай!” хэмээх
их тэмцэлд уриалсан бичгүүд наах болжээ.

Гаднаас хүчээр тулгасан
“социализм” нь
МОНГОЛЫН СОР БОЛСОН
ОЛОН МЯНГАН ЭЛИТҮҮДИЙН
АМЬ НАСАН ДЭЭР, Монгол
төрийн оюун санаа, ой
санамж, тасрах ёсгүй
залгамж чанарыг устгаж
байж тогтсон түүхтэй.

Монголын сэхээрэлт
залуучууд ийнхүү
хүчээр тулгасан
нийгмийн эсрэг босчээ.



<http://npost.mn/>



Залуучуудын уриалгыг монголчууд
дэмжин хүлээн авав. Монгол улсын хаана
л бол хаана социалист гэгдэж байсан
орнуудад өрнөөд байсан өөрчлөн
байгуулалтыг Монгол газар шорооноо
жинхэнэ ёсоор өрнүүлэх ёстой гэсэн үг
үсэг ил тод сонсогдох болов.

1989 оны 11 сарын
27-28-нд Залуу
уран бүтээлчдийн
II зөвлөгөөн
болсон нь
MoAX\Монголын
Ардчилсан
Холбоо\ үүсэх эх
үндэс болсон юм



<https://www.caaknews.mn>



Эрх барьж байсан МАХН -д өөрчлөн
байгуулалтыг түргэтгэх саналыг залуучууд
хүргүүлсэн боловч тэдэнд хариу өгсөнгүй.

Үзэл бодол нэгдсэн залуучууд Монументаль
чимэглэлийн үйлдвэр дээр цуглажээ. Удтал
хэлэлцсэний эцэст ардчиллыг түргэтгэх зорилго
бүхий нэгэн нууц байгууллагыг байгуулав.
Өөрсдийн байгуулсан байгууллагаа тэд
Монголын Ардчилсан Холбоо /МоАХ/ хэмээн
нэрлэжээ.

МоАХ нь 1989 оны 12 сарын 10-нд Нийслэлийн залуучуудын Соёлын төвийн өмнөх талбайд анхны ил тод цуглаанаа хийсэн нь амжилттай болж ардчилсан хүчнийхэнд олон түмэн ихээхэн эрч хүч өгчээ.



<http://www.shuud.mn>

Тэд энэхүү цугалаанаараа МоАХ гэсэн улс төрийн байгууллагаа анх удаа монголын олон нийтэд тунхаглан зарлав.

1990 оны 2-р сарын 18-нд
МоАХ-ны анхдугаар их
хурал хуралдаж МоАХ-ны
нийгмийн бааз дээр
суурилан МоАН
байгуулсаныг албан ёсоор
зарлан тунхаглав.

Ийнхүү ардчилсан хүчин
тэмцлийнхээ явцад улам
зохион байгуулагдаж
Монголд анх удаа МАХН-
аас ангид, ардчиллыг
эрхэм зорилгоо болгосон
цоо шинэ нам
байгуулагдсан нь Монголд
ганц намын ноёрхол унах
эх үндэс болов



Ардчилсан холбооноос зохион байгуулж байсан жагсаал цуглаанд эхний үед 200-300, 2000, 10.000 хүн оролцож байсан бол энэ үед 30.000, 40.000 хүн 1990 оны 3-р сарын 4-нд МоАХ, МоАН бусад ардчилсан хүчнүүдтэй хамтарч зохион байгуулсан жагсаалд 100.000 хүн оролцож Сүхбаатарын талбай жагсагчдаар дүүрч байв.




<http://mongolcom.mm>

Орон нутагт ардчилсан хүчнийхнийг дэмжсэн тэмцэл өрнөж Монгол дахь ардчилсан шинэчлэлт бүх орныг хамарчээ.



<https://www.iri.org>



Ардчилсан хувьсгалын явцад нэг бус удаа цэрэг
цагдаа болж байлдааны бэлэн байдалд орж
байсан хэдий ч Монголчууд энхийн замыг сонгож
байв

БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдээс
1990 оны 5 сарын 15-нд бүх нийтийн сонгууль
явуулах болсноо зарлав

1990 оны 7 сарын 22-нд Монголын түүхэнд анх удаа олон нам оролцсон Чөлөөт ардчилсан сонгууль болов

1990 оны Ардчилсан хувьсгал шинэ нийгэм рүү цус урсгалгүй Сонгуулийн замаар хийгдсэн хувьсгалынхаа хувьд дэлхийн түүхэнд үлгэр дууриал болох хувьсгал байв

1990 оны Монгол дахь ардчилсан шинэчлэлт нь 1921 оны хувьсгалаар тавигдсан зорилт гажсаныг эргүүлэн гольдрогод нь оруулсан түүхэн томоохон үйл явц байлаа.

1911, 1921 оны хувьсгалаар Монголд зах зээлийн харилцаа, капитализмаар баримжаалах хэтийн зорилт тавигдаж байсан бол 1990 оны ардчилсан шинэчлэлтээр мөн энэ л зорилт сэргээн тавигдсан байна.

References

1. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй, Отгонжаргал С, Адмон хэвлэлийн газар, 2003
2. XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн үйл явц, Отгонжаргал С, Бат-Очир Л, Засгийн газрын хэвлэх үйлдвэр, 1996

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА